

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБАНЫ 2023 ОНЫ БАРАА,  
АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАЛТЫН ТУХАЙ ТАЙЛАН

2023.12.01

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Сүхбаатар дүүргийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны алба нь дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны 7/35 дугаар тогтоолоор батлагдсан дүүргийн Төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөөг хүлээн авч, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, холбогдох журам зааварт нийцүүлэн зохион байгуулан ажиллалаа.

**1.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр тоо баримт, биелэлтийн хувийн хамт ерөнхий байдлаар дүгнэн бичнэ.**

**2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт**

а. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:

Дүүргийн ИТХ-аас дүүргийн төсвийн хөрөнгөөр нийт 43633.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд Захиалагчаас захиалгын хуудсын дагуу зарим төсөл арга хэмжээ буюу зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааны хувьд батлагдсан төсөвт өртөг захирамжаар задарч батлагдсантай уялдан төсөл арга хэмжээний тоо нэмэгдэж 72 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд өөрчлөлт орсноор худалдан авах ажиллагааны хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

№	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. Төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн	42083.05	67
2	Тендер үнэлгээний шатанд	42.25	1
3	Төсөв хянуулахаар захиалагчид буцаасан ажлууд	1507.7	4
<b>ДҮН</b>		43633.0	72

Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 93.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлснээр 319.37 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүсгэн ажиллалаа.

б. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:

Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжих 1644.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл арга хэмжээ батлагдсан бөгөөд хэрэгжилт дараах байдалтай байна.

№	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. Төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн	1095.8	9
2	Үнэлгээний хороо байгуулагдсан ХАА-г зохион байгуулсан боловч гүйцэтгэгч шалгараагүй ажлууд	259.7	1
3	Тендер зарлагдаагүй	289.0	2
<b>ДҮН</b>		<b>1644.5</b>	<b>12</b>

Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 75 хувийн гүйцэтгэлтэй байна.

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлсэнээр 34.0 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүсгэн ажиллалаа.

в. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих /худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн/ бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:

Нийслэлийн Засаг даргын эрх шилжүүлсэн захирамжаар нийслэлийн Төсвийн хөрөнгөөр 2022-2023 он дамжин хэрэгжих нийт 317.7 сая төгрөг бүхий 7 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулсан. Мөн 2023 онд Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих нийт 300.0 сая төгрөг бүхий 1 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулсан. 100.0 сая төгрөг бүхий 1 төсөл арга хэмжээний худалдан авалт тендер зарласан шатанд байна.

№	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. Төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн	617.7	8
2	Тендер зарласан шатанд	100.0	1
<b>ДҮН</b>		<b>717.7</b>	<b>9</b>

Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 88.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлсэнээр 16.6 сая төгрөгийн хэмнэлт үүсгэн ажиллаа.

г. Дүүргийн төсвийн бусад эх үүсвэрээр хэрэгжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт.

Дүүргийн Засаг даргын захирамжаар дүүргийн төсвийн бусад эх үүсвэрийн хөрөнгөөр санхүүжих тухайн цаг үеийн шинж чанартай худалдан авалтыг зохион

байгуулахаар 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 10871.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 34 төсөл арга хэмжээ тусгагдсан бөгөөд хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

№	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. Төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн	3533.7	11
2	Тендер зарлагдсан шатанд	270.0	3
3	Төсөв хянуулахаар захиалагчид буцаасан ажлууд	1745.9	8
4	Үнэлгээний хороо байгуулагдсан боловч зарлагдаагүй	450.0	2
5	Үнэлгээний хороо байгуулагдаагүй ажлууд	4871.7	10
<b>ДҮН</b>		10871.3	34

Захирамж гараагүй буюу захиалагчаас захиалгын хуудас ирээгүй нийт 4871.7 төсөвт өртөг бүхий 10 төсөл арга хэмжээний ажлууд байгаа болно.

Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 32.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлсэнээр 91.1 сая төгрөгийн хэмнэлт үүсгэсэн байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны зохион байгуулалт түүний хэрэгжилт

Төлөвлөгдсөн хөрөнгө оруулалтын хүрээнд нийт **28** үнэлгээний хороо Дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан бөгөөд 2023 онд хэрэгжүүлбэл зохих худалдан авах ажиллагааны хэрэгжилт нэгдсэн байдлаар доорх байдалтай байна.

Төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааны хэрэгжилт (2023 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар)

№	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая.төг)		Төсөл арга хэмжээний тоо	
		Хэрэгжүүлбэл зохих	Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжүүлбэл зохих	Бүрэн хэрэгжсэн
1	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт	43633.0	42083.0	72	67
2	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт	1644.6	1095.8	12	9

3	Нийслэлийн Засаг даргаас худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн хөрөнгө оруулалт /НОНХС+НТХО/	717.7	617.7	9	8
4	Бусад эх үүсвэрээс хэрэгжсэн хөрөнгө оруулалт	10871.3	3533.7	34	11
НИЙТ ДҮН		56866.6	47330.2	127	95
Хэрэгжилт		74.8%			

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулснаар нийт 461.07 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүсгэн ажиллалаа. Хэрэгжилт 74.8 хувьтай байна.

Худалдан авах ажиллагааг 100 хувь цахим худалдан авах ажиллагааны журмын дагуу tender.gov.mn цахим системээр зохион байгуулсан бөгөөд тендерийн Үнэлгээний хороодод тус албаны бүх албан хаагчид санамсаргүй байдлаар сонгогдон, нарийн бичгийн даргаар ажиллаж, батлагдсан төлөвлөгөөний дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулж, тендерийн урилга баримт бичиг болон үр дүнгийн мэдээллийг тухай бүрт цахим системээр дамжуулан ил тод, нээлттэй байршуулж иргэд, олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.

Мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах хүрээнд:

- Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын 2023 оны жилийн төлөвлөгөөг дүүргийн Засаг даргаар батлуулан tender.gov.mn, дүүргийн sbd.gov.mn, shilendans.gov.mn, report.ub.procurement.mn сайтуудад, дүүргийн худалдан авах ажиллагааны мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд нээлттэй мэдээллээ.
- 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны мэдээ тайланг ил тод мэдээлсэн бөгөөд тендерийн үр дүнгийн мэдээллийг tender.gov.mn , shilendans.gov.mn, дүүргийн ЗДТГ-ын sbd.gov.mn , report-ubprocurement.mn вэб хуудас болон дүүргийн худалдан авах ажиллагааны мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд мэдээллийг хүргэн ажиллаа.

### **1.2 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэгдээгүй болон дутуу биелсэн ажлын шалтгаан, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны хамт тусгана.**

Худалдан авах ажиллагааны хэрэгжилт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэгдээгүй болон дутуу биелэсэн талаархи тайлбарыг тухайн хөрөнгийн эх үүсвэрийн мэдээллийн дор бүрт нь тайлбар оруулав.

### **1.3 Тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд хийсэн тухай**

2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт 95 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулсан байна. Тус төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд бүрэн хийж захиалагчид үнэлгээний дүгнэлтийг хүргэж ажилласан болно.

### **Худалдан авах ажиллагааны явцад гарсан зөрчил түүнийг хэрхэн засаж залруулсан тухай /тус бүрээр/**

Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын явцад зөрчил гараагүй болно.

#### **1.4 Худалдан авах ажиллагааны талаар гарсан гомдол, түүнийг шийдвэрлэсэн байдал**

2023 оны жилийн эцсийн байдлаар бүрэн зохион байгуулсан 95 төсөл арга хэмжээнээс одоогоор 2 гомдол гарсан. Сангийн Яамнаас худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын баримт бичгийг дахин хянаад, Захиалагчийг холбогдох үнэлгээг дахин хийж, шийдвэр гаргах гэсэн хариу ирүүлсэн бөгөөд шийдвэрийг гарган хүргүүлсэн.

#### **1.5 Чанар стандартын шаардлага хангасан дотоодын бараа худалдан авсан мөнгөн дүн, нийлүүлэгчийн нэр, гэрээний хэрэгжилтийн талаар тусгах**

Дотоодын бараа бүтээгдэхүүний давуу эрхийн зөрүү тооцох зорилгоор Тендерийн баримт бичигт албан хүсэлт болон нотлох баримтыг шаардаж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар дотоодын давуу эрхийн зөрүү тооцсон төсөл арга хэмжээ байхгүй болно.

### **ХОЁР. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМИЙГ АШИГЛАСАН ТАЛААР**

#### **2.1 Худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан тендер шалгаруулалтын тоо, хувь болон системийн талаарх дүгнэж ирүүлнэ.**

Тус алба нь 2023 онд нийслэл, дүүргийн төсвийн болон Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр хэрэгжих нийт 56866.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 127 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байгаагаас 47330.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 95 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим тендерийн системээр бүрэн зохион байгуулаад байна. Мөн цахим тендерийн урилга, үр дүн, гүйцэтгэгчийн гэрээний мэдээллийг тухай бүрд оруулж, нийтэд ил тод нээлттэй ажиллалаа.

#### **2.2 Ерөнхий гэрээ байгуулах журмын дагуу цахим дэлгүүрийн ашиглалт болон тухайн жилд худалдан авсан бараа, үйлчилгээний тоо, мөнгөн дүн, гэрээний хэрэгжилтийн талаар ирүүлнэ.**

Захиалагчийн хувьд ерөнхий гэрээгээр хэрэгжих худалдан авалт байгаагүй тул цахим дэлгүүр ашиглаагүй болно.

### **ГУРАВ. ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

#### **3.1. Тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын тоо, тэдгээрийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн талаар ерөнхий мэдээлэл,**

**худалдан авах ажиллагааг зааварчилгаа, аргачлалаар хангасан байдал болон түүнд хяналт тавьж ажилласан талаар тусгана.**

Дүүргийн төсвийн харъяа 1 байгууллагын (Сүхбаатар дэвшил ОНӨТҮГ) нийт 299.9 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем Tender.gov.mn-р 5 удаа зарласан боловч нэг ч оролцогч тендер ирүүлээгүй тул захиалагчид төсөв хянуулахаар албан бичгээр хүргүүлсэн.

**3.2. Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн харъяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэнд үнэлгээ өгсөн тухай зөвлөмж, дүгнэлт болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг хавсарган ирүүлнэ.**

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, дүүргийн Засаг дарга, түүний Тамгын газрыг худалдан авах ажиллагаатай холбоотой бүх талын мэдээллээр хангах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Захиалагч болох дүүргийн Засаг даргын Тамгын газартай тус алба нь байнга хамтран ажиллаж “Худалдан авах ажиллагааны захиалгын маягт”-ын дагуу төсөл арга хэмжээ бүрийн захиалга даалгаврын хүлээн авч боловсруулан, мэдээ мэдээллийг тухай бүрт нь хүргэн ажиллаа.

## **ДӨРӨВ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТ, САНАЛ**

**4.1. Захиалагчийн тухайн жилийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн үр дүнгийн талаарх өөрийн үнэлгээ, дүгнэлтийг тодруулан гаргаж тавина**

2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт 95 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулсны худалдан авах ажиллагааны журмын сонголт дараах байдалтай байна. Үүнд:

- Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 55 төсөл арга хэмжээ;
- Тендер шалгаруулалтын онцгой журмын харьцуулалтын аргаар 25 төсөл арга хэмжээ;
- Шууд худалдан авалт 6 төсөл арга хэмжээ;
- Зөвлөх үйлчилгээ 9 төсөл арга хэмжээ тус тус зохион байгуулсан байна.

2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааны зохион байгуулалт 74.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулснаар нийт 461.07 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүсгэн ажиллалаа.

**4.2. Гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан тухай**

Гэрээний хэрэгжилтийг захиалагч дүүргийн Засаг даргын Тамгын газраас хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд нийслэлийн Засаг даргаас худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар тус тус хяналт тавьж ажиллаж байна.

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА